



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 504

таний -ны № -т

**Г ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН ИРГЭНИЙ  
ЗОРИГ НОГООН НАМЫН ДАРГА  
Д.БАТ-ОРШИХ ТАНАА**

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн Иргэний зориг ногоон намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн Иргэний зориг ногоон нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн Иргэний зориг ногоон намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Дорнод аймгийн Иргэний зориг ногоон нам"- ын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Дорнод аймгийн Иргэний зориг ногоон нам"- ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд  
Хавсралт . . . хуудастай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

БОЛОРТУУЛ



011020526



ДОРНОД АЙМГИЙН ИРГЭНИЙ ЗОРИГ НГОГООН  
НАМЫН ДАРГА

2117144066  
ЖЮДИК №30891

Иргэний зориг Ногоон Намын  
ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛЫН  
2020 ОНЫ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ДОРНОД аймгийн хөгжлийн зөв чиг, оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, иргэдийнхээ оролцоонд тулгуурладаг, иргэдээз үйлчилдэг, иргэд нь хяналт тавьдаг, орчин цагийн хүн төвтэй шинэ дүүргийн чиг хандлагад нийцүүлэн өөрчлийн тулд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна.

Иргэдийнхээ санап хүсэлд тулгуурлан боловсруулсан АЙМГИЙН ИТХ-Д ДЭВШҮҮЛЭХ “ОРОН НУТГИЙН АМЬДРАЛ” мөрийн хөтөлбөрөө та бүхэнд танилцуулж байна.

## **ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ, ИРГЭД НЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ "ОРОН НУТГИЙН АМЬДРАЛ" ХӨТЕЛВӨР**

### **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**

1. Нас наасны онцлогт, нийгмийн булгийн онцлогыг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн төрөлжсөн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үүнд: Бичил бизнес, Өрхийн үйлдвэрлэл, Уйлчилгээ, Залуучуудад зориулсан гарцааны бизнес буюу "Старт ап" хөтөлбөр, Эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих цогц шинэ бодлогыг боловсруулна.

### **Боловсрол**

2. Тэгш хүртээмжтэй сургууль, цэцэрлэгийн орчинг бий болгох бодлого баримтлан ажиллана.

### **Эрүүл мэнд**

3. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор "ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ", "ЗӨВ ХҮНС" бодлогыг баримталж ажиллана.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвийг байгуулна.
5. Хүүхдийн эмнэлэг байгуулна.

### **Шинэ дэд бүтэц хөтөлбөр**

6. Агаар болон хөрсний бохирдол, орчны бохирдол, авто замын түгжрэл, газар төлөвлөлт, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэх бодлого баримтлаж ажиллана.
7. Гэр хорооллыг орон сууچуулаждаа нийтийн орон сууцнаас хувийн сууцыг давуу хөгжүүлэх бодлого баримтлана.

### **Ногоон аймаг, сум**

8. Барилга байгууламж, дэд бүтцийн төлөвлөлтэнд ногоон технологи, ногоон байгууламжийн шийдлийг стандарт болгон тусган хэрэгжүүлж хэвшүүлнэ.
9. Байгальд ээлтэй нийтэд зориулагдсан соёл, спорт амралтын 4 төвийг төр хувийн хэвшлийг түншлэлээр байгуулна.

### **Засаглал**

10. Иргэд шийдвэр гаргах үйл ажиллагаанд чөлөөтэй оролцдог, санал, хүсэлтээ илэрхийлдэг. хяналт тавьдаг нээлттэй засаглалыг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллана.